



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 21 өдөр

Дугаар А/63.

Хэрлэн сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2018 онд хэрэгжих Сав баглаа боодлын тоног төхөөрөмж авах, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө боловсруулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үүнд:

Дарга:	Э.Мөнх-Эрдэнэ	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	И.Баасанжав	-Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагааны мэргэжилтэн
Гишүүд:	Б.Нямхатан	-Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн
	Д.Оюун	-ТББ-н төлөөлөл
	Т.Эрдэнэбаатар	-ТББ-н төлөөлөл

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга /Э.Мөнх-Эрдэнэ /-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА